

3.2. Төсвийн Ерөнхийлөн захирагчаас ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт

Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 187 дугаар тогтоолоор батлагдсан Төсвийн ерөнхийлөн захирагч ерөнхий менежертэй, ерөнхий менежер нэгжийн менежер /нэгжийн дарга/-тай үр дүнгийн гэрээ байгуулах болон тэдгээрийн биелэлтийг дүгнэх журмыг сум, агентлагуудад хүргүүлж, нэмэлт өөрчлөлтийн талаар байгууллагын дарга нарт зөвлөгөө өглөө. Шинэ журмаар 2010 оны гэрээг дүгнэж, 2011 оны үр дүнгийн гэрээг хийж байна.

Аймгийн ЗДТГ-ын ерөнхий менежер, аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан 2010 оны бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээнд **16** бүтээгдэхүүний ангиар, **32** бүтээгдэхүүн, **15** ажил үйлчилгээ тусган хэрэгжүүлж, гэрээнийхээ үүргийг **94.8%**-тай биелүүллээ.

Тус байгууллага нь 2010 онд орон нутгийн төсвөөс 670.6 сая төгрөг, цэрэг татлага дүйцүүлэхийн зардалд 6.0 сая төгрөг, орон нутгийн хөрөнгө оруулалтаар 173.3 сая төгрөг нийт 849.9 сая төгрөгийн татаас авч, өөрийн орлогод 1938.0 мян төгрөг оруулж, Санхүү, төрийн сангийн хэлтсээс санхүүжүүлсэн цэрэг татлага дүйцүүлэхийн зардлыг өөрийн байгууллагаараа дамжуулан тэдгээрийн зарцуулалтад хяналт тавьж, 842.3 сая төгрөгийн зарлага санхүүжилт хийлээ.

Байгууллагын материаллаг баазыг бэхжүүлэх ажиллагсадын ажиллах нөхцлийг сайжруулах зорилгоор тоног төхөөрөмжид 7.2 сая төгрөг, тавилга эд хогшилд 8.7 сая төгрөг, орон сууцанд 28.2 сая төгрөг, байгууллагын сантехникийн их засварт 148.3 сая төгрөг зарцуулсан байна.